



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**“ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН”
ТӨҮГ-ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: САГ-2018/32/СТА-ТӨҮГ

АУДИТЫН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

**САГ-ын захирал бөгөөд Тэргүүлэх
аудитор** Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахимхаяг: naranchimegts@audit.mn

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 261885
Цахимхаяг: sambuunyamy@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: ЗГ-ын IV байр
Бага тойруу 6, Улаанбаатар 46
Цахим хуудас: www.audit.mn

**“Цэгцтөв богд Аудит” ХХК-ийн
Аудитын багийн ахлагч Н.Цэрэнханд**
Утас:99901517

Улаанбаатар хот



Агуулга

1. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	1
2. АУДИТЫН ТАЙЛАН	1
2.1 ОРШИЛ	1
2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	1
2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН	2
2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АУДИТЫН АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ, ҮР ДҮН	3
2.5 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН	3
2.6 ДОТООД ХЯНАЛТ	4
2.7 ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР	4
2.8 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ	4
2.9 ОЛЖ ТОГТООСОН ГОЛ ЭРСДЭЛҮҮД, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР	4
2.10 ГОЛ, ОНЦЛОГ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР	5
2.11 АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР	5
2.11.1 Татварын тайлагналын талаар	5
2.11.2 Үндсэн хөрөнгийн талаар	5
2.11.3 Бараа материалын талаар	6
2.11.4 Зардлын талаар	7
2.12 МАТЕРИАЛЛАГ БУС ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНУУДЫН ТАЛААРХ ТАЙЛБАР	7
2.13 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ	7
2.14 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД	8
2.15 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	8
2.16 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	8
2.17 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ	8
3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	11
3.1 Санхүүгийн болон татварын тайлагналын талаар	12
3.2 Үндсэн хөрөнгийн талаар	12
3.3 Авлагын талаар	13
3.4 Бараа материалын талаар	13
4. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	15
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	17
4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	19

1. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.15 № 06/694
танай _____-ны № _____-т

“ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН
ХҮРЭЭЛЭН” ТӨҮГ-ИЙН ЗАХИРАЛ
М.ТҮМЭНЖАРГАЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус компанид мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
021731
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ


Үүрэг, хариуцлага

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг тус хүрээлэнгийн захирал М.Түмэнжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, орлого, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгийн элэгдлийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан жишиг хугацааны дагуу тоохон тайлагнах, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, санхүүгийн болон татварын тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно


2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд гэрээгээр “Цэгцтөв Богд аудит” ХХК /САГ-2018/32/СТА-ТӨҮГ/ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.



Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 02 дугаар сарын 25-наас 2018 оны 03 дугаар сарын 12-ныг хүртэл хийхээр төлөвлөн “Цэгцтөв богд аудит” ХХК-ийн 2 дугаар багийн аудитор Д.Үүрийнтуяа, аудиторын туслах ажилтан Г.Дашбалжир нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ нь 2017 оны санхүүгийн тайланг “Цэгцтөв Богд аудит” ХХК-д 2018 оны 02 дугаар 09-ний өдөр 01/76 дугаар албан бичгээр ирүүлсэн.

“Цэгцтөв богд аудит” ХХК нь аудитыг 2018 оны 02 дугаар сарын 25-наас 2018 оны 03 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын удирдлагад гардуулна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН


“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ нь Монгол Улсын Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, ХХОАТ-ын тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай, Эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай, Зөрчлийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын үндсэн зорилт нь эрчим хүчний салбарын ойрын болон дунд хугацаа, хэтийн хөгжлийн бодлого, стратеги боловсруулахад шаардагдах өгөгдөл цуглуулах, эрчим хүчний хэрэглээний таамаглал, эдийн засгийн тооцоо, судалгаа шинжилгээг шинжлэх ухааны үндэстэй боловсруулан гаргах, мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны материал, мэдээллээр эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг хангах, зураг төсөв боловсруулах, шинэ техник, технологийн судалж нэвтрүүлэх, нормативын бичиг баримтыг боловсронгуй болгох замаар эрчим хүчний салбарын хөгжлийг хангахад оршино.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд эрдэм шинжилгээ, судалгааны хэлтэс, зураг төслийн хэлтэс, захиргаа, удирдлагын хэлтэс болон бусад мэргэжилтнүүдийг шуурхай удирдлагаар ханган, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, програм хангамж болон бусад талаар дэмжин ажигладаг байна.

Тус хүрээлэн Шинжлэх ухаан технологи үйлдвэрлэлийн “Эрчим хүчний” нэртэй байсан ба Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 157 болон 206 дугаар



тогтоолоор Эрчим хүчний яамны харьяанд шилжин ирсэн. Эрчим хүчний сайдын 2014 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 94 дүгээр тушаалаар тус байгууллагын оноосон нэр “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ болж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын харьяанд 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 88 дугаар тогтоолоор шилжин ирж үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АУДИТЫН АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ, ҮР ДҮН

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 45-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Эрчим хүчний сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 46 дугаар тушаалаар “Эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын мөрдөх” нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Бид “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерын системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн “ MACS” Инфо системс програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

2.5 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлант оны орлого, үр дүнгийн тайлангийн цэвэр орлого 1,405.7 сая төгрөгийн 2 хувиар буюу 28.1 сая төгрөгөөр тооцов.

2.6 ДОТООД ХЯНАЛТ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Аудитын баг байгууллагын удирдлагад нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа, тайлагнал, дотоод хяналтанд илэрсэн сул талуудыг тухай бүр мэдэгдэж зөвлөмж өгч ажилласан.

2.7 ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР


“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ нь 2017 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 371 дүгээр тушаалаар шинэчлэн батлуулж ажилласан байна. Тус төлөвлөгөөгөөр нийт 1,561.7 сая төгрөгийн төгрөгийн орлого олж 1,313.4 сая төгрөгийг зарцуулан 248.3 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар баталжээ. Тайлант онд гүйцэтгэлээр 1,586.7 сая төгрөгийн орлого олж батлагдсан төлөвлөгөөг 25.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Зардлын хувьд гүйцэтгэлээр нийт 1,175.7 сая төгрөгийг зарцуулж 410.9 сая төгрөгийн татварын өмнөх 369.9 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажилласан байна.

2.8 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас <http://www.meei.energy.gov.mn/> сайтад шилэн дансны цэсийг холбосон байна. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ нь www.shilendans.gov.mn цахим сайтад I) төсөв/гүйцэтгэл; II) хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт; III) бусад; цэсэнд хуульд заасан хугацааны дагуу мэдээлэх үүрэгтэй. Тус хүрээлэн 2017 онд шилэн дансны тухай хууль, журмын дагуу холбогдох мэдээллийг цахим хуудсанд мэдээлсэн ба Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 4.1.2 “төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын зорилтот түвшинг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор” мэдээлнэ заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.9 ОЛЖ ТОГТООСОН ГОЛ ЭРСДЭЛҮҮД, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

Аудитын төлөвлөгөөний дагуу 11 дансанд эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд 45 хяналтын болон нарийвчилсан горим, зорилт гүйцэтгэв.



Аудитын гүйцэтгэлээр төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж авч үзсэн эрсдлүүдээс авлага, үндсэн хөрөнгө, зардлын дансны гүйлгээтэй холбоотой зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.10 ГОЛ, ОНЦЛОГ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин хөлс, орлого, зардлын дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, зардал, хөрөнгийн 85 хувийг эзэлж байна.

2.11 АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР

Аудитын явцад аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансдын нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.11.1 Татварын тайлагналын талаар


- Ажилчдад олгосон хоол унааны хөнгөлөлтөөс 0.3 сая төгрөгийн хувь хүний орлогын алба татварыг дутуу суутгасан. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйл. Шууд бус орлого 15.1-т “Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтнаас албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараахь бараа, үйлчилгээний орлогыг албан татвар ногдох шууд бус орлогод хамруулна: 15.1.1.үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн, түүнчлэн бэлнээр олгосон унааны мөнгө; 15.1.3.бэлнээр олгосон хоолны мөнгө, түүнчлэн үзвэр үйлчилгээний олговор; 22 дугаар зүйл. Бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох 22.1. Дор дурдсан орлогод ногдуулах албан татварыг дараахь байдлаар тодорхойлно: 22.1.4. шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр.” заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу татварыг тооцон тайлагнаж байхыг зөвлөн, зөрчлийг арилгах төлбөрийн акт тогтоов.

2.11.2 Үндсэн хөрөнгийн талаар

- Нийт 188.9 сая төгрөгийн анхны үнэ бүхий биет бус хөрөнгөнд хорогдол байгуулаагүй. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн зааврын 2.2.2-1. Биет бус хөрөнгийн хорогдол. “Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхой бол ашиглалтын хугацаанд хорогдуулна. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхойгүй бол хорогдуулахгүй, үнэ



цэнийн бууралтыг үнэлж, бүртгэнэ. НББОУС 36-ын дагуу ашиглалтын хугацаа тодорхойгүй биет бус хөрөнгийн дансны үнийг нөхөгдөх дүнтэй нь харьцуулах замаар үнэ цэнийн бууралтыг жил бүр шалгаж, үнэ цэнэ буурсан гэх шинж тэмдэг байгаа эсэхийг тодруулна." заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Биет бус хөрөнгийн хорогдлыг хэрхэн тооцож бүртгэх талаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

- Тайлант хугацаанд шинээр худалдаж авсан нийт 105.9 сая төгрөгийн анхны үнэ бүхий үндсэн хөрөнгөнд 0.9 сая төгрөгийн элэгдлийг байгуулаагүй. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн зааврын 5. Элэгдэл. "Нөөц нь шавхагддаггүй хөрөнгөөс бусад бүх хөрөнгийг ашиглагдах боломжит хугацааны туршид тухайн хөрөнгийн анхны өртгөөс элэгдэл тооцож, өртөг зардалд системтэйгээр шингээнэ." заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Үндсэн хөрөнгийн элэгдлийг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан жишиг хугацааны дагуу тооцон тайлагнаж ажиллах зөвлөмж өгөв.

- Нийт 56.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхөн тэг үлдэгдэлтэй болсон байна. Энэ нь УСНББОУС 17-49-д "Хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" заалтыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь:

Анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө цаашид ашиглагдахаар байвал хөрөнгийн дахин үнэлгээ хийх зөвлөмж өгөв.

2.11.3 Бараа материалын талаар

- Бараа материалд Samsung J7 гар утас, зургийн аппарат зэрэг 1.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн. Энэ нь тус газрын захиралтай байгуулсан Контракт (Гэрээ)-ний 3.7 Захирал дараах асуудлыг зөвхөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлөөр шийдвэрлэх үүрэгтэй: 3.7.2-т “үйлдвэрийн газрын үл хөдлөх болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөрөнгө олж авах, данснаас хасах, захиалах, шинээр авах;" гэж заасныг зөрчсөн байна.


Шийдвэрлэсэн нь:

Үндсэн хөрөнгийг олж бэлтгэхдээ холбогдох газрын зөвшөөрлийг аван нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаж ажиллах зөвлөмж өгөв.

- Нийт 1.4 сая төгрөгийн бараа материалыг орлогод авалгүй шууд зардлаар бүртгэсэн. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн зааврын 2.1.4-д "...Бараа материалд...үйлчилгээ үзүүлэхэд ашиглах гэж байгаа материал буюу хангамжийн зүйлс хамрагдана." заалтыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Бараа материалыг орлогод аван холбогдох журмын дагуу бүртгэж ажиллах зөвлөмж өгөв.



2.11.4 Зардлын талаар

- Гүйцэтгэх захиралд дээд газрын шийдвэргүйгээр 2.6 сая төгрөгийн урамшуулал болон хоолны мөнгө олгосон. Энэ нь захиралтай байгуулсан Контракт (Гэрээ)-ний 4.2-т “Захиралд үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон контрактын биелэлтийг харгалзан холбогдох журмын дагуу урамшуулал олгох эсэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар шийдвэрлэнэ.” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Контракт гэрээний заалтуудыг мөрдөж ажиллахыг зөвлөн, зөрчлийг арилгах төлбөрийн акт тогтоов.

2.12 МАТЕРИАЛЛАГ БУС ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНУУДЫН ТАЛААРХ ТАЙЛБАР

Материаллаг бус 4.8 сая төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

2.13 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад анхаарал татахуйц дараах чухал асуудал гарсан болно.


1. Эрчим хүчний сайдын 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 50 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилго бүхий Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 92 дугаар тушаалын дагуу Тусгай зөвшөөрөлтэй холбоотой 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тасалбар болгосон тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нийт 726.2 сая төгрөгийн авлагыг Эрчим хүчний хөгжлийн төвөөс хүлээлгэн өгсөн байна. Энэ нь тус газрын 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингээр батлагдсан 80.0 сая төгрөгийн авлагаас материаллаг хэмжээгээр зөрүүтэй байна. Үүнд:

Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн “Ажил хүлээлцэх тухай” 92 дугаар тушаалаар Тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах комиссын Ажлын албыг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнд шилжүүлсэнтэй холбогдуулан мөн цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтын хураамжийг хүрээлэнд төвлөрүүлэх болсонтойгоор ажил хүлээлцэх комиссыг байгуулжээ.

Тус тушаалын 2 дахь хэсэгт “Ажил хүлээлцэх комисс дор дурдсан арга хэмжээг авч ажилласугай.” 2.1.2-т “тусгай зөвшөөрөлтэй холбоотой өр, авлагын тооцоо, холбогдох баримт бичгийг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнд шилжүүлэх”-ийг даалгасан байна.

Эрчим хүчний хөгжлийн төв нь Эрчим хүчний сайдын 50 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилго бүхий 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 92 дугаар тушаалын дагуу Тусгай зөвшөөрөлтэй холбоотой 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тасалбар болгон дараах өр авлагыг “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-т хүлээлгэн өгсөн байна. Үүнд:

А. 2017 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангийн Тусгай зөвшөөрлийн авлага 1201-00-003 дугаар дансны товчоо тайлан, нийт 281 аж ахуйн нэгж байгууллагын үлдэгдэл 741.4 сая төгрөг /7 хуудас/
Б. Санхүүгийн тайлангийн Урьдчилж тооцсон орлого тусгай зөвшөөрөл 3202-00-001 дугаар дансны товчоо тайлан 741.4 сая төгрөг /8 хуудас/



В. 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс 2017 оны 06 дугаар сарын 30-ныг хүртэлх хугацааны Тусгай зөвшөөрлийн авлага 1201-00-003 тоот дансны товчоо тайлан /Нийт 33 хуудас/

Г. 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс 2017 оны 06 дугаар сарын 30-ныг хүртэлх хугацааны Урьдчилж тооцсон орлого тусгай зөвшөөрөл 3202-00-001 тоот дансны товчоо тайлан /Нийт 36 хуудас /

Д. 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс 2017 оны 06 дугаар сарын 30-ныг хүртэлх хугацааны Тусгай зөвшөөрлийн авлага 1201-00-003 тоот дансны дэлгэрэнгүй бүртгэл /Нийт 261 хуудас/

Е. Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй Тусгай зөвшөөрлийн мэдээллийн сангийн програм хангамж.

1. Эрчим хүчний яамны Төрийн захиргаа удирдлагын газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 1/2352 дугаар “Яамны хурлын танхим тохижуулахад шаардлагатай хөрөнгийг журмын дагуу санхүүжүүлж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана уу.” албан бичгийн дагуу нийт 68.7 сая төгрөгөөр хурлын заалыг засварлан Тусгай зөвшөөрлийн зардал дансанд бүртгэсэн байна.

2.14 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.15 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитаар нийт 12.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 5.0 сая төгрөгийн алдааг тайлант хугацаанд залруулуулж 2.9 сая төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй 4 бүлэг нийт 4.8 сая төгрөгийн зөвлөмжийг Менежментийн захидлаар байгууллагын удирдлагад хүргүүлэв.


2.16 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2016 оны аудитаар төлбөрийн акт, албан шаардлага тогтоогдоогүй бөгөөд авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах зөвлөмж өгсөн байна. Эрчим хүчний хөгжлийн төвөөс шилжиж ирсэн Тусгай зөвшөөрлийн авлагаас бусад авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

2.17 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2017 оны 3-дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн зөрчлөл



болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 14 хуудас, хавсралтууд 5 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН
АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ..... Н.ЦЭРЭНХАНД Огноо:

БЭЛТГЭСЭН:

“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР..... Д.ҮҮРИЙНТУЯА Огноо:





“ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН” ТӨҮГ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

САГ-ын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахимхаяг: naranchimegts@audit.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 261885
Цахимхаяг: sambuunyamy@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: ЗГ-ын IV байр
Бага тойруу 6, Улаанбаатар 46

“Цэгцтөв богд Аудит” ХХК-ийн Аудитын багийн ахлагч Н.Цэрэнханд
Утас:99901517

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1 Санхүүгийн болон татварын тайлагналын талаар.....	1
Асуудал 2 Үндсэн хөрөнгийн талаар.....	2
Асуудал 3 Авлагын талаар.....	3
Асуудал 4. Бараа материалын талаар.....	4

Улаанбаатар хот



3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгдсэн ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Энэ нь “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3.1 Санхүүгийн болон татварын тайлагналын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

Аудитын ажиглалт

- ✓ Өмчийн өөрчлөлтийн тайланг батлагдсан маягтын дагуу бүрэн тайлагнаагүй.
- ✓ Валютийн ханшийн бодит ба бодит бус орлогыг 0.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- ✓ Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг тохируулах тайланг дутуу тайлагнасан.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

Аудитын зөвлөмж

- ✓ Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 361 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг мөрдөх.
- ✓ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн холбогдох заалтын дагуу тайлагнаж байх.
- ✓ Сангийн сайдын 2010 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам"-ыг мөрдөх.

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулан зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхээр болов.

3.2 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

Аудитын ажиглалт

- ✓ Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан жишиг хугацааг баримтлаагүй.
- ✓ Нийт 188.9 сая төгрөгийн анхны үнэ бүхий биет бус хөрөнгөнд хорогдол байгуулаагүй.
- ✓ Тайлант хугацаанд шинээр худалдаж авсан нийт 105.9 сая төгрөгийн анхны үнэ бүхий үндсэн хөрөнгөнд 0.9 сая төгрөгийн элэгдлийг байгуулаагүй.

Аудитын зөвлөмж

- ✓ Эрчим хүчний сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 46 дугаар тушаалаар батлагдсан Эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийн 9.9 "Үндсэн хөрөнгийн ашиглалтын жишиг хугацаа"-г хэрэгжүүлэх.
- ✓ Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн зааврыг мөрдөх.
- ✓ Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн зааврыг мөрдөж ажиллах.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

- ✓ Нийт 56.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхөн тэг үлдэгдэлтэй болсон байна.
- ✓ Хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулан зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхээр болов.

3.3 Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

Аудитын ажиглалт

- ✓ Эрчим хүчний сайдын 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 50 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилго бүхий Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 92 дугаар тушаалын дагуу Тусгай зөвшөөрөлтэй холбоотой 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тасалбар болгосон тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нийт 726.2 сая төгрөгийн авлагыг Эрчим хүчний хөгжлийн төвөөс хүлээлгэн өгсөн байна.

Аудитын зөвлөмж

- ✓ Авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулж ажиллах.

- ✓ Санхүүгийн болон татварын тайлангаарх нэмэгдсэн өртгийн албан татварын авлага 0.006 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.2.7-т "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих,..." заалтыг хэрэгжүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулан зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхээр болов.

3.4 Бараа материалын талаар


Тэргүүлэх ач холбогдол №1

Аудитын ажиглалт

- ✓ Бараа материалд Samsung J7 гар утас, зургийн аппарат зэрэг 1.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн.

Аудитын зөвлөмж

- ✓ Үндсэн хөрөнгийг олж бэлтгэхдээ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлөөр шийдвэрлэж байх.



- ✓ Нийт 1.4 сая төгрөгийн бараа материалыг орлогод авалгүй шууд зардлаар бүртгэсэн.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

- ✓ Бараа материалыг орлогод аван зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулан зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхээр болов.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ Н.ЦЭРЭНХАНД

Огноо:

БЭЛТГЭСЭН:

“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР Д.ҮҮРИЙНТУЯА

Огноо:



4. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	2016.12.31	2017.12.31
1.ХӨРӨНГӨ		
1.1.Эргэлтийн хөрөнгө		
1.1.1. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	20,113,464.13	164,060,473.21
1.1.2. Дансны авлага	294,890,363.00	319,080,410.17
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	-	2,754,737.44
1.1.4. Бусад авлага	1,446,819.00	1,026,484,895.01
1.1.5. Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6. Бараа материал	25,747,412.97	40,642,759.13
1.1.7. Урьдчилж төлсөн зардал/ тооцоо		
1.1.8. Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	342,198,059.09	1,553,023,274.96
1.2. Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1 Үндсэн хөрөнгө	70,026,895.79	173,995,301.24
1.2.2 Биет бус хөрөнгө	197,498,223.08	198,072,596.39
1.2.3 Биологийн хөрөнгө		
1.2.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5 Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6 Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8 Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	267,525,118.88	372,067,897.63
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	609,723,177.97	1,925,091,172.59
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1 Өр төлбөр		
2.1.1 Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1 Дансны өглөг	29,239,444.07	1,944,000.07
2.1.1.2 Цалингийн өглөг	-	-
2.1.1.3 Татварын өр	41,037,130.39	19,255,828.33
2.1.1.4 НДШ-ийн өр	8,112,362.24	-
2.1.1.5 Банкны богино хугацаат зээл		
2.1.1.6 Хүүний өглөг		
2.1.1.7 Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8 Урьдчилж орсон орлого	247,544.63	1,002,927,775.53
2.1.1.9 Нөөц өр төлбөр		
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	78,636,481.33	1,024,127,603.93
2.1.2 Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1 Урт хугацаат зээл		
2.1.2.2 Нөөц өр төлбөр		
2.1.2.3 Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5		



2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2 Өр төлбөрийн нийт дүн	78,636,481.33	1,024,127,603.93
2.3 Эздийн өмч	50,942,564.92	50,942,564.92
2.3.1 Төрийн	50,942,564.92	50,942,564.92
2.3.2 Хувийн		
2.3.3 Хувьцаат		
2.3.4 Халаасны хувьцаа		
2.3.5 Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	241,520,901.21	241,520,901.21
2.3.7 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	4,170,141.37	4,170,141.37
2.3.9 Хуримтлагдсан ашиг	234,453,089.14	604,329,961.16
2.3.10		
2.3.11 Эздийн өмчийн дүн	531,086,696.64	900,963,568.66
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	609,723,177.97	1,925,091,172.59

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	2016.12.31	2017.12.31
1. Борлуулалтын орлого (Цэвэр орлого)	405,754,344.69	1,405,682,468.30
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	169,240,787.11	138,672,176.60
3. Нийт ашиг (алдагдал)	236,513,557.58	1,267,010,291.70
4. Түрээсийн орлого		
5. Хүүний орлого	353,443.84	6,243,723.80
6. Ногдол ашгийн орлого		
7. Эрхийн шимтгэлийн орлого		
8. Бусад орлого	276,288,493.60	174,107,346.51
9. Борлуулалт, маркетингийн зардал		
10. Ерөнхий ба удирдлагын зардал	572,880,190.61	1,034,122,685.75
11. Санхүүгийн зардал		
12. Бусад зардал	4,081,417.86	2,936,568.68
13. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	98,520.47	672,194.66
14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15. Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16. Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17. Бусад ашиг (алдагдал)		
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	63,707,592.98	410,974,302.24
19. Орлогын татварын зардал	35,344.38	41,097,430.22
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	63,742,937.36	369,876,872.02
21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	63,742,937.36	369,876,872.02
23. Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн		
25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	НТК	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Салбар өмчлөлийн өөрчлөлтөөс нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИИТ ДҮН
1	2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	50,942,564.92			241,520,901.21		4,170,141.37	299,167,666.50	595,801,274.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								-
3	Залруулсан үлдэгдэл	50,942,564.92	-	-	241,520,901.21	-	4,170,141.37	299,167,666.50	595,801,274.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(63,742,937.36)	(63,742,937.36)
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
6	Өмчид гарсан өөрчлөлт								-
7	Зарласан ногдол ашиг							(971,640.00)	(971,640.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
9	2016 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	50,942,564.92	-	-	241,520,901.21	-	4,170,141.37	234,453,089.14	531,086,696.64
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								-
11	Залруулсан үлдэгдэл	50,942,564.92	-	-	241,520,901.21	-	4,170,141.37	234,453,089.14	531,086,696.64
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							369,876,872.02	369,876,872.02
13	Бусад дэлгэрэнгүй орлого								-
14	Өмчид гарсан өөрчлөлт								-
15	Зарласан ногдол ашиг								-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	50,942,564.92	-	-	241,520,901.21	-	4,170,141.37	604,329,961.16	900,963,568.66

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлтийн нэр	2016.12.31	2017.12.31
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	738,965,425.01	1,625,568,919.78
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	685,633,962.51	1,326,441,007.98
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	7,272,105.00	11,837,718.00
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	46,059,357.50	287,290,193.80
1.2 Мөнгөн зарлагын дүн	721,535,982.62	1,339,573,684.16
Ажиллагчдад төлсөн	293,976,990.50	389,160,701.90
Нийгмийн даатгалын байгуулгад төлсөн	71,061,079.00	108,257,201.11
Бараа материал худалдан авахад төлсөн	7,261,057.45	55,104,215.41
Ашиглалтын зардал төлсөн	8,756,911.00	4,914,654.56
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,690,199.55	2,953,800.00
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгуулгад төлсөн	19,947,310.00	115,179,332.64
Даатгалын төлбөрт төлсөн	7,899,386.00	14,453,724.00
Бусад мөнгөн зарлага	306,943,049.12	649,550,054.54
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	17,429,442.39	285,995,235.62
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	353,443.84	(142,048,226.54)
Мөнгөн орлогын дүн	353,443.84	6,243,723.80
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого	353,443.84	6,243,723.80
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн		(148,291,950.34)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		143,291,950.34
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		5,000,000.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	353,443.84	(142,048,226.54)
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(971,640.00)	
Мөнгөн орлогын дүн		
Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Мөнгөн зарлагын дүн	971,640.00	
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж авхад төлсөн		
Төлсөн ногдол ашиг	971,640.00	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	16,811,246.23	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	16,811,246.23	143,947,009.08
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,302,297.90	20,113,464.13
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,113,464.13	164,060,473.21

